



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2025/001/НА-СТА-ТЕЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэт хот 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvar@audit.gov.mn Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Оргилмөрөн Утас: 70357955 Цахим хаяг: orgilmurung@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.04.21 № 97.
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Орхон аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын засгийн газар хооронд байгуулсан санхүүгийн протокол, хөнгөлөлттэй зээлийн гэрээний дагуу хэрэгжсэн "Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл төсөл"-ийн зээлийн үндсэн төлбөрт 2022-2024 онд 16,802.6 сая төгрөг, хүүгийн зардалд 1,231.8 сая төгрөг төлсөн байна. Уг ажлын туршилт тохируулга хийгдээгүй, улсын комисс хүлээж аваагүйтэй холбоотойгоор төслийг 2025 онд багтаан дуусгаж, ашиглагч байгууллага болох Эрдэнэт үйлдвэр хүлээн авахаар Барилга хот байгуулалтын сайд, Орхон аймгийн Засаг дарга, Эрдэнэт үйлдвэрийн ерөнхий захирлын хамтарсан санамж бичиг байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Төрийн албан хаагчийн цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн баталсантай холбоотойгоор цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 49.7 хувиар өссөн байна.

Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-ын 5 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 11/04 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтад заасны дагуу улсын төсвийн 85 байгууллагын төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдад 6,620.7 сая төгрөгийн орон нутгийн нэмэгдэл цалин олгосон байна.

Бусад асуудал

Засгийн газрын шийдвэрийн дагуу Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас аймгийн автозамын засвар, шинэчлэлтийн ажилд зориулж 50,000.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор Орхон аймаг, Эрдэнэт үйлдвэрийн хамтын ажиллагааны гэрээнд тусган аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны төсөвт баталсан байна.

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас 2024 оны санхүүгийн жилд 20,000.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож бүтээн байгуулалтын ажил хийгдэж эхэлсэн бөгөөд автозамын ажлууд он дамжин хэрэгжихтэй холбоотойгоор 2025 оны төсөвт үлдсэн 30,000.0 сая төгрөгийг авахаар тооцоолж эх үүсвэрийг орон нутгийн хөгжлийн санд нэмэгдүүлж баталсан байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		105,193,258.7	90,463,669.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	55,645,600.0	52,612,705.3
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	4а, 4б	0.0	0.0
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	22,468,487.2	25,108,891.5
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	14,842,127.4	71,091.4
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	12,187,484.1	12,584,280.8
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	49,560.0	86,700.0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	0.0	0.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		284,401,929.5	388,639,282.3
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	100,000.0	100,000.0
37100	Урт хугацаат хадгаламж		0.0	0.0
37200	Үнэт цаас		100,000.0	100,000.0
37300	Урт хугацаат зээл		0.0	0.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	284,301,929.5	388,539,282.3
39100	Газар		0.0	0.0
39200	Биет хөрөнгө		273,286,395.0	374,410,318.2
39300	Биет бус хөрөнгө	13	11,015,534.5	14,128,964.2
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	0.0	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		389,595,188.2	479,102,951.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		32,729,967.4	39,046,513.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	25,647,075.6	30,824,784.6
41100	Богино хугацаат үнэт цаас		0.0	0.0
41200	Богино хугацаат зээлийн өглөг	16а, 16б	0.0	0.0
41300	Өглөг	17а, 17б	24,022,395.9	28,851,072.6
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	1,624,679.6	1,973,712.1
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		7,082,891.8	8,221,728.9
42100	Урт хугацаат үнэт цаас	19	0.0	0.0
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	7,082,891.8	8,221,728.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		356,865,220.9	440,056,437.8
51	Засгийн газрын хувь оролцоо		356,865,220.9	440,056,437.8
51100	Засгийн газрын оруулсан капитал		16,845,008.0	16,867,163.0
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		26,181,818.5	33,473,249.0
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/		0.0	0.0
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/		0.0	0.0
51104	Халаасны хувьцаа /ТӨҮГ/		0.0	0.0
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/		0.0	0.0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		64,822,824.7	72,108,732.2
51200	Хуримтлагдсан үр дүн		233,817,852.1	302,466,223.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		15,197,717.6	15,141,069.9
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		0.0	0.0
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		0.0	0.0
51600	Нөөцийн сан		0.0	0.0
52	Хяналтын бус хувь оролцоо		0.0	0.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		389,595,188.2	479,102,951.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		354,134,609.5	427,353,247.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО		257,455,381.9	246,389,667.7
110	Орлогын албан татвар		202,406,053.8	189,287,333.4
1100	Хувь хүний орлогын албан татвар		68,039,751.4	94,405,623.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-4,484,320.1	-5,118,290.2
1103	ААН-ын орлогын албан татвар		138,850,622.5	100,000,000.0
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар		0.0	0.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого		0.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар		21,379,837.5	23,512,312.4
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар		0.0	0.0
115	Онцгой албан татвар		0.0	0.0
116	Тусгай зориулалтын орлого		0.0	0.0
117	Гадаад үйл ажиллагааны орлого		0.0	0.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж		33,669,490.5	33,590,021.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	73,638,316.3	170,334,174.6
120	Нийтлэг татварын бус орлого		49,823,218.0	109,300,064.2
121	Хөрөнгийн орлого		4,432,825.0	2,192,710.4
122	Тусламжийн орлого		2,600,000.0	25,361,200.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		16,782,273.3	33,480,200.0
124	Зээлийн орлого		0.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		23,040,911.3	10,629,404.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	256,070,572.3	288,061,384.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ		256,070,572.3	288,061,384.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		88,496,039.6	128,867,299.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		15,455,524.6	27,955,964.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,845,512.7	2,681,147.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		917,062.7	4,930,094.7
2104	Хангамж, бараа материалын зардал		5,833,110.1	9,417,881.0
2105	Нормативт зардал		214,398.9	219,156.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,546,502.3	3,342,912.8
2107	Томилот, зочны зардал		192,440.1	321,676.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		33,362,861.9	52,899,784.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		29,128,626.3	27,098,681.7
211	ХҮҮ		235,531.5	14,842,127.4
212	ТАТААС		1,217,712.2	1,452,636.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		166,121,289.0	142,899,320.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		98,064,037.2	139,291,862.9
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		521,312.0	777,337.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		36,993,575.6	73,405,989.7
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		61,591,773.6	66,663,210.8

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	286,493,826.2	0.0	286,493,826.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-43,954.8	0.0	-43,954.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	286,449,871.4	0.0	286,449,871.4
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-43,864.0	0.0	-43,864.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	637,247.0	0.0	637,247.0
7	Өмчид гарсан өөрчлөлт	8,230,192.9	0.0	8,230,192.9
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	61,591,773.6	0.0	61,591,773.6
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	356,865,220.9	0.0	356,865,220.9
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	356,865,220.9	0.0	356,865,220.9
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,985,160.7	0.0	1,985,160.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	358,850,381.6	0.0	358,850,381.6
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-56,647.6	0.0	-56,647.6
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	117,960.0	0.0	117,960.0
17	Өмчид гарсан өөрчлөлт	14,481,533.1	0.0	14,481,533.1
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	66,663,210.8	0.0	66,663,210.8
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	440,056,437.8	0.0	440,056,437.8

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		346,223,077.4	362,388,075.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО		257,455,381.9	245,965,057.2
110	Орлогын албан татвар		202,405,793.8	188,862,147.8
1100	Хувь хүний орлогын албан татвар		68,039,491.4	93,980,438.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-4,484,320.1	-5,118,290.2
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч		0.0	0.0
1103	ААН-ын орлогын албан татвар		138,850,622.5	100,000,000.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого		0.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар		21,379,837.5	23,512,312.4
116	Тусгай зориулалтын орлого		0.0	0.0
117	Гадаад үйл ажиллагааны орлого		0.0	0.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж		33,669,750.5	33,590,596.9
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		3,138,281.0	4,540,218.7
1181	Газрын төлбөр		30,005,843.4	27,986,310.5
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		525,626.1	1,064,067.7
1183	Бусад татвар		0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		64,033,264.2	106,233,392.3
120	Нийтлэг татварын бус орлого		40,218,166.0	70,560,481.9
121	Хөрөнгийн орлого		4,432,825.0	2,192,710.4

122	Тусламжийн орлого		2,600,000.0	0.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		16,782,273.3	33,480,200.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		24,734,431.4	10,189,625.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		258,821,469.2	264,956,686.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ		258,821,469.2	264,956,686.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		88,030,191.3	117,629,888.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		21,154,566.8	35,622,953.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,869,203.9	4,991,871.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,762,523.3	6,110,941.6
2104	Хангамж, бараа материалын зардал		5,773,075.3	5,904,087.6
2105	Нормативт зардал		207,427.8	367,443.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,435,253.3	3,478,401.9
2107	Томилолт, зочны зардал		192,440.1	321,676.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		39,049,376.7	49,828,424.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		15,586,324.0	11,004,089.3
211	ХҮҮ		1,461,460.1	2,956,816.8
212	ТАТААС		1,217,712.2	1,452,636.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		168,112,105.6	142,917,343.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		87,401,608.2	97,431,389.0
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		20,036.7	5,178.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		75,097,229.3	100,554,372.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		75,097,229.3	100,554,372.8
2200	Дотоод эх үүсвэрээр		75,097,229.3	100,554,372.8
2260	Гадаад эх үүсвэрээр		0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-75,077,192.6	-
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		-194,824.7	84,910.8
14	Бусад эх үүсвэр		483,575.3	395,033.8
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		513,400.0	250,738.2
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР		0.0	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		165,000.0	59,384.8
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		12,129,591.0	-3,032,894.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		43,516,009.1	55,645,600.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		55,645,600.0	52,612,705.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	392,657,206.0	316,663,244.2
УРСГАЛ ЗАРДАЛ	227,340,255.4	214,707,930.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	81,961,527.2	69,726,181.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	30,776,893.6	27,705,403.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,961,037.1	2,659,540.7

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,237,669.3	5,499,660.9
Хангамж, бараа материалын зардал	3,616,976.4	3,128,311.4
Нормативт зардал	219,503.4	212,393.2
Эд хогшил, урсгал засварын зардал	3,994,932.5	3,701,472.3
Томилолт, зочны зардал	395,218.1	308,667.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,690,739.2	24,935,157.2
Бараа үйлчилгээний бусад зардал	2,068,557.6	1,575,574.6
ТАТААС	1,600,000.0	1,452,636.8
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,600,000.0	1,452,636.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	140,821,911.4	140,572,295.1
Засгийн газрын урсгал шилжүүлэг	138,514,945.4	138,514,945.4
Бусад урсгал шилжүүлэг	2,306,966.0	2,057,349.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	164,743,159.1	101,704,575.7
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	573,791.5	250,738.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	392,657,206.0	317,981,693.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	34,710,272.0	33,480,200.0
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	257,009,001.2	258,324,851.9
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	100,937,932.8	26,176,641.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		9,015,869.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		10,334,317.9
БАЙГУУЛЛАГЫН ТОО	0.0	0.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	1.0	0.9
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1.0	0.9

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,207,590.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,207,590.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,435,040.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	162,814.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,042.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,620.0
2104	Хангамж, бараа материалын зардал	267,378.3
2105	Нормативт зардал	155,050.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	238,249.8
2107	Томилолт, зочны зардал	13,009.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,504,844.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	73,031.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,772,550.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	413,699.6
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,358,850.8
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,207,590.7
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,207,590.7
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0

Гурав. Аудитын илрүүлэлт:

3.1 Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагч, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайлангийн аудит.

Орхон аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд тайлангаа нэгтгүүлдэг нийт 43 санхүүгийн тайланг аудитад хамруулахаар төлөвлөж /үүнд: 8 өрхийн эрүүл мэндийн төв орсон/, 42 санхүүгийн тайланг аудитад хамруулсан байна. Үүнээс 18 тайланг түүвэрт хамруулж, 25 тайланд санал дүгнэлт гаргасан байна.

Хүснэгт 12. Санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлт

№	Байгууллагын ангилал	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр (тоогоор)					Түүвэр	Нийт дүн
		Санал дүгнэлт гаргасан						
		Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Татгалзсан	Хамрагдаагүй			
1	Төсөвт байгууллага	13	1			2	16	
2	Төсөл, сан	2				8	10	
3	Өрхийн эрүүл мэндийн төв					8	8	
4	ОНӨААН	6		1			7	
5	ТТЗ	1			1		2	
	ДҮН	22	1	1	1	18	43	

Аудитад хамруулаагүй 1 тайлан нь Баян-Өндөр сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан бөгөөд аймгийн төвийн сум болох Баян-Өндөр суманд 2023 оноос төрийн сангийн нэгж байгуулагдаж үйл ажиллагаа явуулж буй боловч санхүүгийн тайлангийн нэгтгэлийн системд /Э-тайлан/ төвлөрүүлэн захирагчийн эрх нээгдээгүйтэй холбоотойгоор тус сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланг тусад нь гаргаж ирүүлээгүй, аудитад хамруулаагүй байна.

Санал дүгнэлт гаргасан 25 байгууллагаас Өөрчлөлтгүй - 22, Хязгаарлалттай – 1 /Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн газар/, Дүгнэлт гаргахаас татгалзсан -1 /Жаргалант ус дулаан түгээх станц/ санал дүгнэлт хүргүүлэн байна.

Дээрх төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн 43 санхүүгийн тайлангийн аудитаар нийт 24,385.9 сая төгрөгийн 15 алдаа¹ илэрснээс аудитын явцад 24,385.9 сая төгрөгийн 15 алдааг залруулсан байна. Үүнд: Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан 1,350.7 сая төгрөгийн 7 алдаа, буруу тусган илэрхийлсэн 23,035.2 сая төгрөгийн 8 алдаа байна.

Тухайлбал: Аймгийн ОНХС-ийн санхүүгийн байдлын тайланд 1,219.5 сая төгрөгийн урьдчилж орсон орлогыг тусгаагүй, Хот тохижуулах газрын санхүүгийн үр дүнгийн тайланд 59.5 сая төгрөгийн дээд шатны төсвийн захирагчаас өгсөн санхүүжилтийг тайлагнаагүй, үнэ төлбөргүй хүлээн авсан 22,717.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тодруулга тайланд худалдан авснаар тайлагнасан зэрэг болно.

Санхүүгийн тайлангийн түвшинд нийт 1,020.4 сая төгрөгийн 143 зөрчил² илэрснээс, 59.1 сая төгрөгийн 39 төлбөрийн акт тогтоож, 409.2 сая төгрөгийн 39 албан шаардлага, 552.1 сая төгрөгийн 63 зөвлөмж өгч, 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 2 албан шаардлага тус тус хүргүүлсэн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2 Орхон аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит.

Орхон аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад дараах өөрчлөлтүүд орж, залруулга хийлээ. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд урт хугацаат хөрөнгө оруулалтын үнэт цаас ангиллын 100.0 сая төгрөгийг урт хугацаат зээл ангилалд тайлагнасан,
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд татварын орлогын 460.3 сая төгрөгийг татварын бус орлогоор, цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын 7.0 сая төгрөгийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаар тус тус алдаатай тайлагнасан, хангамж, бараа материалын зардлыг 13.6 сая, төлбөр хураамжийн зардлыг 1.7 сая төгрөгөөр тус тус илүү илэрхийлж тусламж санхүүжилтийн орлогыг нэмэгдүүлсэн,
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд урсгал шилжүүлгийг 104.3 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 13.6 сая төгрөгөөр тус тус илүү, төлбөр хураамжийн зардлыг 47.1 сая төгрөгөөр дутуу илэрхийлснээр урсгал зардал болон тусламж санхүүжилтийн орлогыг нэмэгдүүлсэн байна.

Аудитаар нийт 1,597.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 0.8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 1,596.5 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын болон Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 2,617.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь төлөвлөлтийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшин 4,791.3 сая төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдлын 70% буюу 3,353.9 сая төгрөгөөс хэтрээгүй тул "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт өгөхөөр шийдвэрлэлээ.

3.2.1 Төлбөрийн акт

Уурын зуухан галлагаатай боловсролын байгууллагуудад 2024 оны 09 сараас 12 сарын хооронд нийлүүлсэн нүүрсний үнийн зөрүүтэй холбоотой 0.8 сая төгрөгийн акт тогтоов.

3.2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Жижиг дунд үйлдвэр болон өрхийн бичил үйлдвэрлэлийг дэмжих зорилготой Төрийн банканд байршиж байсан 300.0 сая төгрөгийн гэрээний хугацаа дуусгавар болж Төрийн банкнаас гэрээг дахин сунгахгүй болсонтой холбоотойгоор данс эзэмшигч нь орон нутагт шилжиж санхүүгийн нэгтгэсэн тайланд тус мөнгийг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Төрийн сангийн арилжааны банканд дахь үлдэгдлээр тайлагнасан байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 35.3-д "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банкинд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ", Сангийн сайд, Монгол банкны ерөнхийлөгчийн хамтарсан 2022 оны А122/А-172 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Засгийн газар болон төсвийн байгууллагын дансыг банканд нээх, хаах, тайлагнах журам"-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр аливаа хэлбэрээр арилжааны банканд данс нээхгүй байх.

2. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Баян-Өндөр сумын төвлөрүүлэн захирагчийн орон нутгийн төсвийн суурь орлого болох хувь хүний орлогын албан татварын орлогын 330.7 сая төгрөгийг Жаргалант сумын төсөвт төвлөрүүлсэн байна. /БОЭТ-өөс 200.0 сая төгрөг, Цагдаагийн газраас 130.7 сая төгрөг/.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.6.2-т "төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх", 6.6.6-д "тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх", 22.1-д "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", 23.8-д "Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ:", 23.8.17-д "Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д заасан орлогод ногдох албан татвар" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн байгууллагуудын төвлөрүүлж буй татварын орлогын гүйлгээг тухайн шатны төсөвт төвлөрүүлж буй эсэхэд тавих хяналтыг сайжруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар татварын байгууллага, аймаг, сумдын төрийн сангийн нэгжид үүрэг, чиглэл өгч ажиллах.

3. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутгийн ерөнхий орлогын тайланд 10-аас дээш жилийн насжилттай 2023 онд хаагдсан төрийн албан хаагчийн орон сууцны сангийн 212.4 сая, мөн хаагдсан боловсрол, эрүүл мэндийг дэмжих сангийн 2.0 сая, бусад 124.0 сая төгрөгийн, Эрдэнэт сангийн санхүүгийн тайланд хариуцах эзэн холбогдогч нь бүрэн тодорхойгүй, эргэн төлөгдөх магадлал бага 2000-2010 оны хооронд үүссэн зээлийн хүүгийн 2.7 сая, Эрдэнэт-Оргил ХХК-ийн 77.3 сая, Жаргалант сумын ногоочдын холбооны 15.0 сая, Бурхан багшийн сэрэг дүрийн ашиглалтын өмнөх захиргааны 5.0 сая нийт 438.4 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Сүүлийн жилүүдэд эдгээр авлагыг барагдуулах, баталгаажуулах дорвитой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн ерөнхий орлогын болон Эрдэнэт сангийн тайланд бүртгэлтэй нийт 438.4 сая төгрөгийн авлагыг хариуцагч тус бүрээр дэлгэрэнгүй тодорхойлж, төлөгдөх боломжтой авлагыг барагдуулах үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлж, найдваргүй авлагын талаар хууль, тогтоомжийн хүрээнд эрх бүхий этгээдийн холбогдох шийдвэрийг гаргуулж баталгаажуулах.

4. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутгийн өмчиж аж ахуйн тооцоот Их шүтээн цогцолбор тайлант онд орон нутгаас 68.4 сая төгрөгийн татаас авсан, 181.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан, Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа 406.5 сая төгрөгийн татаас авсан, 306.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан, Гэр бүлийн ордон 39.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан, цэвэр өөрийн хөрөнгө -65.9 сая төгрөг болсон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2-д "Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие

даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ", Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жил бүр алдагдалтай ажилладаг, орон нутгийн төсвөөс санхүүждэг орон нутгийн өмчит газруудын үйл ажиллагаа, чиг үүрэг, хэрэгцээ шаардлагыг иж бүрэн тодорхойлж, холбогдох байгууллагад нэгтгэх, оновчтой зохион байгуулах, удирдлага, менежментийг сайжруулах, үр ашигтай ажиллуулах асуудлыг судалж, шийдвэрлэх.

5. Төсвийн төвлөрүүлэн захирагчтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Орхон аймгийн Баян-Өндөр суманд 2023 оноос төрийн сангийн нэгж байгуулагдаж үйл ажиллагаа явуулж буй боловч санхүүгийн тайлангийн нэгтгэлийн системд /Э-тайлан/ эрх нээгээгүй, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэж ирүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8.9.2-д "төсвийн төвлөрүүлэн захирагч ... жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Баян-Өндөр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хууль, тогтоомжийн хүрээнд нэгтгэн гарган ирүүлж, аудитад хамруулах

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл – Төсвийн ерөнхийлөн захирагч

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд урт хугацаат хөрөнгө оруулалтын үнэт цаас ангиллын 100.0 сая төгрөгийг урт хугацаат зээл ангилалд тайлагнасан	1	100.0			1	100.0	1	100.0				
Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд татварын орлогын 460.3 сая төгрөгийг татварын бус орлогоор, цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын 7.0 сая төгрөгийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаар тус тус алдаатай тайлагнасан, хангамж, бараа материалын зардлыг 13.6 сая, төлбөр хураамжийн зардлыг 1.7 сая төгрөгөөр тус тус илүү илэрхийлж тусламж санхүүжилтийн орлогыг нэмэгдүүлсэн	1	482.6			1	482.6	1	482.6				
Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд урсгал шилжүүлгийг 104.3 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 13.6 сая төгрөгөөр тус тус илүү, төлбөр хураамжийн зардлыг 47.1 сая төгрөгөөр дутуу илэрхийлснээр урсгал зардал болон тусламж санхүүжилтийн орлогыг нэмэгдүүлсэн байна	1	165.0			1	165.0	1	165.0				
ДҮН	3	747.6			3	747.6	3	747.6				

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл - Байгууллагаар

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орхон аймгийн Баян-Өндөр сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	165.4	0	0.0	1	165.4	1	165.4	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	1.0	0	0.0	1	1.0	1	1.0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Нийтлэг үйлчилгээний алба	3	7.7	2	0.4	1	7.3	3	7.7	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Баян-Өндөр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	0.1	1	0.1	0	0.0	1	0.1	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	1	0.5	0	0.0	1	0.5	1	0.5	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар	1	24.3	0	0.0	1	24.3	1	24.3	0	0.0	0	0.0
Эрдэнэт хотын захирагчийн алба	1	16.5	0	0.0	1	16.5	1	16.5	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газар	1	102.6	0	0.0	1	102.6	1	102.6	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Жаргалант сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	46.6	1	46.6	0	0.0	1	46.6	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	1	1,219.5	1	1,219.5	0	0.0	1	1,219.5	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Хот тохижуулах газар	3	22,801.8	2	84.2	1	22,717.6	3	22,801.8	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Засаг дарга	3	747.6			3	747.6	3	747.6				
ДҮН	18	25,133.5	7	1,350.7	11	23,782.8	18	25,133.5	0	0.0	0	0.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл – Төсвийн ерөнхийлөн захирагч

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Дүн	Тоо	Дүн
Жижиг дунд үйлдвэр болон өрхийн бичил үйлдвэрлэлийг дэмжих зорилготой Төрийн банканд байршиж байсан 300.0 сая төгрөгийн гэрээний хугацаа дуусгавар болж Төрийн банкнаас гэрээг дахин сунгахгүй болсонтой холбоотойгоор данс эзэмшигч нь орон нутагт шилжиж санхүүгийн нэгтгэсэн тайланд тус мөнгийг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Төрийн сангийн арилжааны банканд дахь үлдэгдлээр тайлагнасан байна.	1	300.0					1	300.0					
Нүүрс худалдан авах ОРАХААГ/20240102203 дугаар гэрээний дагуу 2024 оны 09 сараас 12 сарын хооронд 22-р цэцэрлэг, 28-р цэцэрлэг, 20-р сургууль, 11-р цэцэрлэг, 17-р сургуульд нийлүүлсэн 425 тонн нүүрсний 1 тонн тутмыг гэрээний үнээс 1,807.90 төгрөгөөр илүү дүнгээр нэхэмжилж нийт 767,931 төгрөгийн санхүүжилтийг Засаг даргын төсөл хөтөлбөрийн данснаас илүү олгосон байна.	1	0.8	1	0.8									
Баян-Өндөр сумын төвлөрүүлэн захирагчийн орон нутгийн төсвийн суурь орлого болох хувь хүний орлогын албан татварын орлогын 330.7 сая төгрөгийг Жаргалант сумын төсөвт төвлөрүүлсэн байна. /БОЭТ-өөс 200.0 сая төгрөг, Цагдаагийн газраас 130.7 сая төгрөг/.	1	330.7					1	330.7					

Орхон аймгийн Баян-Өндөр суманд 2023 оноос төрийн сангийн нэгж байгуулагдаж үйл ажиллагаа явуулж буй боловч санхүүгийн тайлангийн нэгтгэлийн системд /Э-тайлан/ эрх нээгээгүй, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэж ирүүлээгүй байна.	1	0					1	0.0				
Орон нутгийн ерөнхий орлогын тайланд 10-аас дээш жилийн насжилттай 2023 онд хаагдсан төрийн албан хаагчийн орон сууцны сангийн 212.4 сая, мөн хаагдсан боловсрол, эрүүл мэндийг дэмжих сангийн 2.0 сая, бусад 124.0 сая төгрөгийн, Эрдэнэт сангийн санхүүгийн тайланд хариуцах эзэн холбогдогч нь бүрэн тодорхойгүй, эргэн төлөгдөх магадлал бага 2000-2010 оны хооронд үүссэн зээлийн хүүгийн 2.7 сая, Эрдэнэт-Оргил ХХК-ийн 77.3 сая, Жаргалант сумын ногоочдын холбооны 15.0 сая, Бурхан багшийн сэрэг дүрийн ашиглалтын өмнөх захиргааны 5.0 сая нийт 438.4 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Сүүлийн жилүүдэд эдгээр авлагыг барагдуулах, баталгаажуулах дорвитой арга хэмжээ авч ажиллаагүй байна.	1	438.4					1	438.4				
Орон нутгийн өмчиж аж ахуйн тооцоот Их шүтээн цогцолбор тайлант онд орон нутгаас 68.4 сая төгрөгийн татаас авсан, 181.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан, Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа 406.5 сая төгрөгийн татаас авсан, 306.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан, Гэр бүлийн ордон 39.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан, цэвэр өөрийн хөрөнгө -65.9 сая төгрөг болсон байна.	1	527.4					1	527.4				
Дүн	6	1,597.3	1	0.8			5	1,596.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл - Байгууллагаар

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан тушаалтны тоо	Дүн	Тоо
Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	3	0.0	0	0.0	0	0.0	3	0.0	0	0	0.0	0	0.0
Анхны оч өрхийн эрүүл мэндийн төв	1	0.0	0	0.0	0	0.0	1	0.0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Жаргалант сумын Засаг дарга	4	0.6	0	0.0	1	0.6	2	0.0	1	1	0.0	0	0.0
Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газар	6	60.4	0	0.0	4	58.7	2	1.6	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Жаргалант сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	2.5	0	0.0	0	0.0	1	2.5	0	0	0.0	0	0.0
Мөнх сүндрэл өрхийн эрүүл мэндийн төв	4	1.4	3	1.4	0	0.0	1	0.0	0	0	0.0	0	0.0
Мөнхийн гэгээ өрхийн хэрүүл мэндийн төв	1	0.3	1	0.3	0	0.0	0	0.0	0	0	0.0	0	0.0
Мэнд цэцэн өрхийн эрүүл мэндийн төв	3	22.4	2	1.6	0	0.0	1	20.8	0	0	0.0	0	0.0
Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв	2	0.7	2	0.7	0	0.0	0	0.0	0	0	0.0	0	0.0
Орон нутгийн хөрөнгө оруулалт	1	8.5	0	0.0	1	8.5	0	0.0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн аялал жуулчлал амралтын их шүтээн цогцолбор	4	0.2	1	0.1	0	0.0	3	0.1	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Байгаль орчны газар	4	4.4	1	0.2	2	4.1	1	0.0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газар	6	119.6	2	12.6	2	97.9	2	9.1	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Баян-Өндөр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	6	4.8	1	0.6	2	4.2	3	0.0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Баян-Өндөр сумын Орон нутгийн хөгжлийн сан	1	46.9	0	0.0	0	0.0	1	46.9	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сан	2	14.8	0	0.0	0	0.0	2	14.8	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Гэр бүлийн ордон	2	0.3	1	0.3	0	0.0	1	0.0	0	0	0.0	0	0.0

Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	5	7.2	2	3.2	0	0.0	3	4.0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Жаргалант сумын Орон нутгийн хөгжлийн сан	2	262.0	0	0.0	0	0.0	2	262.0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Засаг даргын тамгын газар	11	40.3	2	1.0	5	39.4	4	0.0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Мэдээлэл шуурхай удирдлагын төв	2	1.5	0	0.0	1	1.5	1	0.0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Нийтлэг үйлчилгээний алба	4	3.3	2	1.6	2	1.8	0	0.0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газар	5	8.4	0	0.0	3	7.8	2	0.6	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	3	5.1	0	0.0	1	1.7	2	3.3	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Сум дундын ойн анги	3	4.6	1	0.2	1	4.4	1	0.0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Хот тохижуулах газар	5	51.9	3	11.9	1	40.0	0	0.0	1	1	0.0	0	0.0
Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газар	2	4.0	0	0.0	1	4.0	1	0.0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар	8	81.4	2	7.9	2	1.8	4	71.6	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Эрдэнэт Сан	4	106.1	0	0.0	1	19.2	3	86.9	0	0	0.0	0	0.0
Учралтбаяр өрхийн эрүүл мэндийн төв	4	1.2	2	1.2	0	0.0	2	0.0	0	0	0.0	0	0.0
Үйлс бадрах өрхийн эрүүл мэндийн төв	3	4.4	1	0.4	0	0.0	2	4.0	0	0	0.0	0	0.0
Хот байгуулалт, барилга захиалагчийн алба	7	29.1	2	5.0	3	20.6	2	3.4	0	0	0.0	0	0.0
Энхжих мандариваа өрхийн эрүүл мэндийн төв	2	0.3	1	0.3	0	0.0	1	0.0	0	0	0.0	0	0.0
Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ	10	41.2	3	4.0	3	20.4	4	16.9	0	0	0.0	0	0.0
Эрдэнэт хотын захирагчийн алба	3	0.1	1	0.1	1	0.0	1	0.0	0	0	0.0	0	0.0
Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа	5	6.2	2	1.2	1	1.5	2	3.5	0	0	0.0	0	0.0
Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк	4	74.3	1	3.0	1	71.3	2	0.0	0	0	0.0	0	0.0
Орхон аймгийн Засаг дарга	6	1,597.3	1	0.8			5	1,596.5					
Дүн	149	2,617.7	40	59.8	39	409.3	68	2,148.6	2	2	0.0	0	0.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал - Байгууллагаар

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Орхон аймгийн Нийтлэг үйлчилгээний алба	1	0.0			1			
Үйлс бадрах өрхийн эрүүл мэндийн төв	1	0.0					1	
Орхон аймгийн Гэр бүлийн ордон	1	0.0					1	0.0
Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газар	1	0.0					1	0.0
Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар	1	0.0					1	0.0
Эрдэнэт хотын захирагчийн алба	1	0.0			1	0.0		
Орхон аймгийн аялал жуулчлал амралтын их шүтээн цогцолбор	1	0.0					1	0.0
Орхон аймгийн Хот тохижуулах газар	1	0.0			1	0.0		
Дүн	8	0.0	0	0.0	3	0.0	5	0.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Мэнд цэцэн өрхийн эрүүл мэндийн төв	1	0.0			1	0.0		
Мөнхийн гэгээ өрхийн эрүүл мэндийн төв	1	0.0					1	0.0
Мөнх сүндрэл өрхийн эрүүл мэндийн төв	1	0.0			1	0.0		
Нийцэл өрхийн эрүүл мэндийн төв	2	0.2					2	0.2
Энхжих мандариваа өрхийн эрүүл мэндийн төв	1	0.0					1	0.0
Үйлс бадрах өрхийн эрүүл мэндийн төв	1	0.0					1	0.0
Учралтбаяр өрхийн эрүүл мэндийн төв	1	0.0					1	0.0
Дүн	8	0.2	0	0.0	2	0.0	6	0.2
Нийт дүн	16	0.2	0	0.0	5	0.0	11	0.2